

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГСА-2021/49/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойр

2021 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа

Утас: 7054-3156

Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр

Утас: 7054-3179

Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Аудитор: Б.Дарханбат

Утас: 7054-3179

Цахим хаяг: Darkhanbatb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govsumber@audit.gov.mn

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН
АЛБАНЫ ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Н.АЛТАНЦЭЦЭГ ТАНАА

2021.02.15 № 10
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлэгдсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус газарт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

003020013

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,795,957.00	2,400,150.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,795,957.00	2,400,150.00
354	Хангамжийн материал	2,795,957.00	2,400,150.00
35410	Бичиг хэргийн материал	576,657.00	382,850.00
35420	Аж ахуйн материал	522,000.00	600,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	123,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,697,300.00	1,294,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,316,800.58	6,104,846.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,316,800.58	6,104,846.10
392	Биет хөрөнгө	5,285,978.70	6,104,846.10
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	4,893,700.00	5,773,700.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,189,270.05)	(3,347,210.08)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,366,650.00	4,916,350.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(785,101.25)	(1,237,993.82)
393	Биет бус хөрөнгө	30,821.88	-
39301	Програм хангамж	500,000.00	500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(469,178.12)	(500,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,112,757.58	8,504,996.10
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,112,757.58	8,504,996.10
51	Засгийн газрын хувь оролцоо	8,112,757.58	8,504,996.10
512	Хуримтлагдсан үр дүн	8,112,757.58	8,504,996.10
51210	Өмнөх үеийн үр дүн	8,112,757.58	8,112,757.58
51220	Тайлант үеийн үр дүн	-	392,238.52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,112,757.58	8,504,996.10

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	61,490,900.00	67,975,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	61,490,900.00	67,975,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	61,490,900.00	67,975,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,490,900.00	67,975,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	58,093,900.55	67,583,161.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	58,093,900.55	67,583,161.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	56,823,900.55	64,388,050.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	43,172,800.29	49,573,110.00
210101	Үндсэн цалин	43,172,800.29	49,573,110.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,396,599.71	6,216,015.00
210201	Тэтгэврийн даатгал	3,669,687.54	4,243,691.00
210202	Тэтгэмжийн даатгал	431,728.20	493,082.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	345,383.93	394,466.00
210204	Ажилгүйдлийн даатгал	86,346.44	98,616.00
210205	Эрүүл мэндийн даатгал	863,453.60	986,160.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,083,043.00	4,084,771.00
210401	Бичиг хэрэг	914,750.00	1,363,617.00
210402	Тээвэр, шатахуун	1,562,200.00	1,357,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	597,593.00	631,354.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	3,600.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	8,500.00	-
210408	Бараа материал акталсны зардал	-	729,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,029,300.00	2,264,500.00
210702	Дотоод албан томилолт	3,029,300.00	2,264,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	582,000.00	324,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	180,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	252,000.00	324,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,560,157.55	1,925,654.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,000.00	38,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	180,000.00	246,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,360,157.55	1,641,654.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,270,000.00	3,195,111.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,270,000.00	700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,270,000.00	700,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,495,111.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,495,111.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	3,396,999.45	392,238.52
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	3,396,999.45	392,238.52

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	61,490,900.00	67,975,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	61,490,900.00	67,975,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	61,490,900.00	67,975,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,490,900.00	67,975,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	57,890,300.00	65,545,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	57,890,300.00	65,545,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	56,620,300.00	62,350,589.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	42,813,200.00	49,508,555.00
210101	Үндсэн цалин	29,135,900.00	27,500,575.00
210102	Нэмэгдэл	12,958,600.00	18,792,880.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	718,700.00	3,215,099.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,756,200.00	6,280,570.00
210201	Тэтгэврийн даатгал	4,426,200.00	4,237,870.00
210202	Тэтгэмжийн даатгал	332,500.00	511,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	266,000.00	408,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	66,500.00	102,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	665,000.00	1,021,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,819,600.00	3,550,964.00
210401	Бичиг хэрэг	1,442,907.00	1,406,300.00
210402	Тээвэр, шатахуун	1,480,200.00	1,480,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	646,493.00	664,464.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	250,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	120,000.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	120,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	3,029,300.00	2,264,500.00
210702	Дотоод албан томилолт	3,029,300.00	2,264,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	582,000.00	500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	180,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	252,000.00	500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	246,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	246,000.00

Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,270,000.00	3,195,111.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,270,000.00	700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,270,000.00	700,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,495,111.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,495,111.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>3,600,600.00</u>	<u>2,429,700.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,600,600.00	2,429,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,600,600.00	2,429,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,600,600.00	2,429,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,600,600.00	2,429,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(3,600,600.00)</u>	<u>(2,429,700.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	4,715,758.13	0.00	4,715,758.13
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	4,715,758.13	0.00	4,715,758.13
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	8,112,757.58	0.00	8,112,757.58
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	8,112,757.58	0.00	8,112,757.58
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	8,112,757.58	0.00	8,112,757.58
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	8,112,757.58	0.00	8,112,757.58
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	392,238.52	0.00	392,238.52
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	8,504,996.10	0.00	8,504,996.10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	67,975,400.00	65,480,289.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	67,975,400.00	65,480,289.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	67,275,400.00	64,780,289.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	51,086,000.00	49,508,555.00
210101	Үндсэн цалин	29,248,000.00	27,500,575.00
210102	Нэмэгдэл	18,214,300.00	18,792,880.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,623,700.00	3,215,099.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,397,000.00	6,280,570.00
210201	Тэтгэврийн даатгал	4,354,300.00	4,237,870.00
210202	Тэтгэмжийн даатгал	511,100.00	511,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	408,300.00	408,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	102,000.00	102,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,021,300.00	1,021,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,569,600.00	3,550,964.00
210401	Бичиг хэрэг	1,363,400.00	1,363,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,480,200.00	1,480,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	726,000.00	707,364.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,447,500.00	2,429,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,447,500.00	2,429,700.00
2107	Томилолт, зочны зардал	3,029,300.00	2,264,500.00
210702	Дотоод албан томилолт	3,029,300.00	2,264,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	500,000.00	500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	246,000.00	246,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	246,000.00	246,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	700,000.00	700,000.00

Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2132	Бусад урсгал шилжүүлэг	700,000.00	700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	700,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	3.00	3.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	2.00	2.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	3.00	3.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	3.00	3.00

Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн шууд захирагч Н.Алтанцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд цахим төлбөрийн системд хяналт тавьж, төлбөрийн баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэх талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 20-ноос 2021 оны 02 дугаар сарын 05-ны хооронд Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Дарханбат хариуцаж хэрэгжүүлэв.

Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 15-ны өдрийн 14 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь тайлант хугацаанд 11 зорилт 22 арга хэмжээ төлөвлөж, 20 арга хэмжээг 100 хувь, 2 арга хэмжээг 70% хэрэгжүүлж жилийн эцсийн байдлаар 94.5 хувийн биелэлттэй гэж тайлагнажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Сангийн яамны дотоод аудитын газраас Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны санхүүгийн үйл ажиллагаа болон шилэн дансанд дотоод аудит хийгээгүй байна.

Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны 3-р улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 46,281.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 694.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 67,583.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцож 1,013.7 мянган төгрөгөөр тогтоов.

Энэ нь завсрын аудитаар материаллаг байдлын суурийг 3-р улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс тооцсонтой холбоотой.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 392.2 мянга төгрөгөөр буюу 4.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	2,795.90	2,400.10	-395.8
Үндсэн хөрөнгө	5,316.80	6,104.80	788
Нийт хөрөнгө	8,112.70	8,504.90	392.20
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	8,112.70	8,504.90	392.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	8,112.70	8,504.90	392.2

Мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөрийн дансанд өөрчлөлт ороогүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2,400.1 мянган төгрөг болж өмнөх оноос 395.8 мянган төгрөгөөр буурч, үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 788.0 мянган төгрөгөөр өссөн байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 2,795.9 мянган байсан бөгөөд 2,981.7 мянган төгрөгийн материал худалдан авч, 3,377.5 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж 2,400.1 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан.

Үндсэн хөрөнгийн данс нь 8,504.9 мянган төгрөг болж оны эхнээс 788.0 мянган төгрөг буюу 14.8 хувиар нэмэгдсэн байна.

Оны эхэнд 8,760.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд урсгал төсвийн зардлаас 2,429.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, эд хогшил худалдан авч, 11,190.0 мянган төгрөгийн дансны үнэтэй үндсэн хөрөнгө 5,085.2 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүртгэж, 6,104.8 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй үндсэн хөрөнгийг бүртгэж тайлагнажээ.

Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 67,975.4 мянган төгрөг болж өмнөх оноос 6,484.5 мянган төгрөгөөр буюу 10.5 хувиар нэмэгдсэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс орон нутгийн төсвийн санхүүжилт 6,484.5 мянган төгрөгөөр өссөн нь цалин НДШ-ийн төсөв нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Харин нийт зардал 67,583.1 мянган төгрөг болж өмнөх оноос 9,489.2 мянган төгрөгөөр буюу 16.3 хувиар өсжээ. Өмнөх оны үзүүлэлтээс цалин, НДШ-ийн зардал 7,219.7 мянган төгрөгөөр нэмэгдэж материаллаг өөрчлөлт гарсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 110,534.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 110,534.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 42,588.6 мянган төгрөгөөр бууруулж 67,975.4 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төсөлд тусгагдсан саналаас 26,510.2 мянган төгрөгийн цалин НДШ-ийн зардал, 2,370.4 мянган төгрөгийн хангамж бараа материалын зардал, 5,654.5 мянган төгрөгийн эд хогшил, урсгал засварын зардал, 2,019.0 мянган төгрөгийн дотоод албан томилолтын зардал, 3,050.0 мянган төгрөгийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 2,200.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг хасаж баталсан нь нөлөөлжээ.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх "70417-Мэргэжлийн хяналт" хөтөлбөрийн 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал арга хэмжээнд 67,275.4 мянга, 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал арга хэмжээнд 700.0 мянга, нийт 67,975.4 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 67,975.4 мянган төгрөгийн санхүүжилт авч 65,480.3 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 2,495.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 65,480.3 мянган төгрөг буюу 96.3 хувьтай байгаа нь цалин НДШ-ийн зардал 1,693.8 мянга, дотоод албан томилолт 764.8 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь "70417-Мэргэжлийн хяналт" хөтөлбөрийн 80101-Үндсэн үйл ажиллагааны зардлаас 2,495.1 мянган төгрөг хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Мөнгөн гүйлгээ, санхүүгийн үр дүнгийн тайланд санхүүжилт 67,975.4 мянган төгрөгийг тайлагнасан байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө батлагдаагүй байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын хувьд нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 137 мэдээлэл, хугацаа болоогүй 2, хугацаа хоцроосон 10 мэдээлэл байна.

Шилэн дансны мэдээллийг мөнгөн гүйлгээ болон анхан шатны баримт материалтай тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Шилэн дансны цахим хуудсанд A/06 тоот хөрөнгө зарцуулах тушаалыг оруулаагүй.
2. 10 мэдээллийг хугацаа хоцроосон.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд тус байгууллагад итгэл үзүүлсэн тул зөвлөмж, акт, албан шаардлага өгөөгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 547.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 547.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулж, 1 албан шаардлага, 1 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Бараа материалын тайланд орлогын баримтыг данс бүрд нь бичиж хавсаргаагүй, нярвын тайланг улирал бүр орлого, зардлыг давхар тайлагнасан, замын хуудасны тооцоог бодохдоо спидометрийн заалтыг үндэслээгүй байна.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар шилэн данстай холбоотой залруулагдаагүй 1 алдаа, зөрчил илэрсэн бөгөөд алдаа зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлээ.

1. Шилэн дансны цахим хуудсанд А/06 тоот хөрөнгө зарцуулах тушаалыг оруулаагүй, 10 мэдээлэл хугацаа хоцорсон байна. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.6, 6.4.5, 6.3.6, 6.3.7, 6.4.4, 6.4.8 дахь заалтуудыг зөрчсөн ба үнэн зөв байх, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

Аудитын зөвлөмж

Аудитаар цахим төлбөрийн систем болон төлбөрийн баримттай холбоотой илэрсэн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал илрээгүй.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *Цахим төлбөрийн систем, төлбөрийн баримттай холбоотой асуудал*
 - 1.1. Илрүүлэлт: Цахим татварын системд худалдан авалтын мэдээлэл тохирч байгаа эсэхэд хяналт тавьж ажиллаагүй. Тухайлбал: цахим төлбөрийн баримтыг 476.1 мянгаар дутуу, 163.6 мянган төгрөгөөр илүү тусгасан.
 - 1.2. Эрсдэл: Худалдан авалтуудыг цахим төлбөрийн системд мэдээлэхгүй байх, татвар төлөгч нар орлогоо нуух, холбогдох хууль тогтоомж зөрчигдөх, байгууллагын удирдлага хариуцлага хүлээх
 - 1.3. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.5-д заасныг хэрэгжүүлэх, цахим татварын систем дэх худалдан авалтын төлбөрийн баримтад хяналт тавьж, тулган баталгаажуулах
 - 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			GCA-2021/49/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд А/06 тоот хөрөнгө зарцуулах тухай тушаалыг оруулаагүй, 10 мэдээлэл хугацаа хоцорсон.	0	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	Н.Алтанцэцэг Л.Одонтуяа
2	Бараа материалын тайланд орлогын баримтыг данс бүрт нь бичиж хавсаргаагүй, няравын тайланд зөвхөн тайлант хугацааны орлого, зардлыг бүртгээгүй, замын хуудасны тооцоог бодохдоо спидометрийн заалтыг үндэслээгүй.	547.2	Залруулга	Дарга Нягтлан бодогч	Н.Алтанцэцэг Л.Одонтуяа
3	Цахим татварын системд худалдан авалтын үнийн дүнг тулган баталгаажуулж, хяналт тавьж ажиллаагүй. Тухайлбал: төлбөрийн баримтыг 476.1 мянгаар дутуу, 163.6 мянган төгрөгөөр илүү тусгасан.	0	Зөвлөмж	Дарга Нягтлан бодогч	Н.Алтанцэцэг Л.Одонтуяа
ДҮН		547.2			

Маягт № В501

Ажлын баримтын нэр:

Залуулаагүй буруу шэрхийлэл буку алба, зөрчилтэй асуудлын бүртгэл

Ажлын баримтын дугаар:

В501

ГСА-2021/49/СТА-ТШЗ

төгрөгөөр

Аудитын нэр:

Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны санхүүгийн тайлангийн аудит

№	Аудитын шийтгэл	Тогоо	Алдаа, зөрчлийн төмөр утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Аудит хийлгэсэн байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар	Гаргасан шийдэл	Үнэлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	Овог нэр
А	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Шалгалт дансанд	1	Шалгалт дансны цахим хуудсанд А06 тоот хөрөнгө зарцуулах тушаалыг оруулаагүй, 10 мэдээлэл хугацаа хоцорсон.	-	Албан шаардлага	Хүлээн зөвшөөрсөн		Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	Н.Алтанцацэг Л.Одонтуяа
2	Баруун материалын	1	Баруун материалын тайлан дунд орлогын баримтыг данс бүрт нь бичиж хансаргах, нэрлэлийн тайлан дунд зөвхөн тайлант хугацааны орлого, зардлыг бүртгэх, замын хуудасны тооцоог бодохдоо спецификарийн заалтыг үндэслэх	547 260.0	Залуулга	Хүлээн зөвшөөрсөн		Залуулга	Дарга Нягтлан бодогч	Н.Алтанцацэг Л.Одонтуяа
3	Цахилгаан тусгаарлах систем	1	Цахилгаан тусгаарлах системд тусгаарлах баримтыг 476.1 мянгаар бууруу, 103.9 мянган төгрөгөөр нүүг тусгасан	-	Зөвлөмж	Хүлээн зөвшөөрсөн		Зөвлөмж	Дарга Нягтлан бодогч	Н.Алтанцацэг Л.Одонтуяа
Нийт				547 260.0						

Бэлтгэгч:

Ажлын аудитор Б.Дарамбаа

Ажлын шатанд илэсэн:

Аудитын менежер Г.Наранбаатар

Хоёр дахь шатанд илэсэн:

Дарга, Түрүүлэгч аудитор Б.Сарантуяа

Танилцаж зөвшөөрсөн:

Дарга Н.Алтанцацэг

Нягтлан бодогч Л.Одонтуяа

Огноо

Огноо

Огноо 2021.02.15

Огноо 2021.02.15

Огноо 2021.02.15



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 01/05

Чойр

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд А/06 тоот хөрөнгө зарцуулах тухай тушаалыг оруулаагүй, 10 мэдээллийг хугацаа хоцроосон.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "мэдээлэл, үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.2 "хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор," 6.1.6 "төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр", 6.3.6 "хөрөнгийн болон үрсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл", 6.3.7 "хөрөнгө оруулалтын зарлага, санхүүжилтийг төсөл, объект тус бүрээр" 6.4.4 "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг" 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд дээрх зөрчлүүдийг арилган биелэлтийг 2021 оны 03 дугаар сарын 01-ний дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх;

¹ Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, АЗДТГ-ын байр, Утас:70543156

0809000324

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга Н.Алтанцэцэг, нягтлан бодогч Л.Одонтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР



Б.ДАРХАНБАТ